

БАТЛАВ

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН ДАРГА

..... Д.МӨРӨН

БАТЛАВ

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА

..... Б.НЯМДАВАА

МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ГЭРЭЭ

2019 оны 10 дугаар сарын
16 -ний өдөр

№ 2019/016, XX ҮЕГ/29 Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нэг талаас Гадаадын иргэн, харьяатын газар /цаашид "ГИХГ" гэх/ түүнийг төлөөлж тус газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ш.Алтантулга, нөгөө талаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /цаашид "ХХҮЕГ" гэх/ түүнийг төлөөлж Мэдээллийн технологийн төвийн дарга Д.Даваажаргал нар /хамтад нь "Талууд" гэх/ дараах нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2. Энэхүү гэрээгээр Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ыг тус тус үндэслэн гэрээний хавсралтад заасан мэдээллийг /цаашид мэдээллийн сан гэх/ цахим хэлбэрээр харилцан шилжүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.4. Гэрээний хугацаа дуусахад Талуудаас гэрээг цуцлах тухай санал гаргаагүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгасанд тооцно.

1.5. Гэрээний дагуу зөвшөөрөгдсөн мэдээллийг авахдаа төрийн цахим мэдээлэл солилцох систем, сервэр хооронд үүсгэсэн сервисийг ашиглана.

1.6. Гэрээний хавсралт энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

Хоёр. Талуудын нийтлэг эрх, үүрэг

2.1. Талууд Үндэсний Дата Төвөөс шилэн кабелиар мэдээлэл авах дэд бүтцийг бүрдүүлсэн байна.

2.2. Гэрээгээр хүлээх эрх, үүргийг бүхэлд нь буюу хэсэгчлэн бусдад шилжүүлэхийг хориглоно.

2.3.Талууд мэдээллийн санг цахимаар шилжүүлэн авах тус бүр "нэг эрх"-тэй байх бөгөөд мэдээлэл авах эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх, солих тохиолдолд нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

2.4.Мэдээллийн санг функцээр хүлээн авахдаа хэрэглэгчийн нэр, нууц үгийг ашиглах бөгөөд хэрэглэгчийн нэр, нууц үгийг Талуудаас томилсон эрх бүхий албан тушаалтан хариуцан ажиллаж, мэдээллийн санг албан хэрэгцээнд ашиглана.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1.Мэдээллийн сангийн аюулгүй байдал, мэдээлэл солилцох нөхцөл бололцоог хангах, хэрэгжилтэд хяналт тавих, эрхгүй этгээдийг мэдээллийн санд нэвтрүүлэхгүй байх;

3.2.Энэхүү гэрээний дагуу мэдээллийг авахад зориулж мэдээлэлд хандах гаралтын функцыг бэлтгэх;

3.3.Тодорхой шалтгааны улмаас мэдээллийг солилцох боломжгүй болсон тохиолдолд гарсан доголдлыг хамтран шуурхай засварлах;

3.4.Мэдээллийн нэгдсэн санд хандаж байгаа програм хангамжийг хувилж тараах, бусдад шилжүүлэхгүй байх;

3.5.Мэдээллийн санд холбогдсон компьютерийг бусад байгууллага, хувь хүнд шилжүүлэх, засвар, үйлчилгээ хийлгэхгүй байх.

Дөрөв. Хяналт тавих

4.1.Талууд мэдээллийн санг зориулалтын бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, нууцлалыг хадгалах зорилгоор сүлжээний аюулгүй байдал, техник, програм хангамжид харилцан хяналт тавина.

4.2.Мэдээллийн сангийн дамжуулалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой үйл ажиллагаанд Талуудын дотоодын хяналт тавих нэгж /газар, хэлтэс/-үүд хяналт тавина.

4.3.Хүлээн авсан мэдээллийг ашиглах явцад хууль тогтоомж болон энэ гэрээг зөрчсөн байж болзошгүй нөхцөл илэрсэн тохиолдолд харилцан мэдэгдэж зөрчлийг арилгах талаар хамтран ажиллана.

Тав. Гэрээ хүчин төгөлдөр болох, нэмэлт өөрчлөлт оруулах, бусад


5.1.Энэхүү гэрээ Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

5.2.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлтийг харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.3.Талууд гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГИХГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

ВИЗ, ЗӨВШӨӨРӨЛ, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГАЧ.НАРМАНДАХМЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧШ.АЛТАНТУЛГАЭРХ ЗҮЙ, ГАДААД ХАРИЛЦААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГАЧ.ТУЛГАЦООДОЛ

ХХҮЕГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ГАЗРЫН ДАРГАЗ.БУЯНБАДРАХМЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ТӨВИЙН ДАРГАД.ДАВААЖАРГАЛЭРХ ЗҮЙ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГАГ.ГАНЗАЯА

ГИХГ, ХХҮЕГ – ын хооронд байгуулсан 2019 оны
 2019/01/16 / ХХҮЕГ-ын дугаартай "Мэдээлэл солилцох гэрээ"-ний 1 дүгээр хавсралт
 29

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРААС
 ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАРТ ӨГӨХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Оролтын утга	Гаралтын утга
1.Хөдөлмөр эрхлүүлэхээр урьсан зөвшөөрөл	
Уригч байгууллагын регистрийн дугаар ХХҮЕГ-ын албан бичгийн дугаар	Овог
	Нэр
	Төрсөн огноо
	Хүйс
	Паспортын дугаар
	Улс
	Хөдөлмөр эрхлэх хаягийн бүртгэл /аймаг, нийслэл, дүүрэг/
	Уригч байгууллагын регистрийн дугаар
	Уригч байгууллагын нэр
	Ажиллах салбар
	ХХҮЕГ-ын албан бичгийн дугаар
2.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох	
Уригч байгууллагын регистрийн дугаар ХХҮЕГ-ын албан бичгийн дугаар	Овог
	Нэр
	Төрсөн огноо
	Хүйс
	Паспортын дугаар
	Улс
	Хөдөлмөр эрхлэх хаягийн бүртгэл /аймаг, нийслэл, дүүрэг/
	Уригч байгууллагын регистрийн дугаар
	Уригч байгууллагын нэр
	Ажиллах салбар
	Хөдөлмөрлөж эхлэх хугацаа
	Хөдөлмөрлөж дуусах хугацаа
	ХХҮЕГ-ын албан бичгийн дугаар
3.Хөдөлмөр эрхлэх хугацааг сунгах зөвшөөрөл	
Уригч байгууллагын регистрийн дугаар ХХҮЕГ-ын албан бичгийн дугаар	Овог
	Нэр
	Төрсөн огноо

	Хүйс
	Паспортын дугаар
	Улс
	Хөдөлмөр эрхэлж байгаа хаягийн бүртгэл /аймаг, нийслэл, дүүрэг/
	Уригч байгууллагын регистрийн дугаар
	Уригч байгууллагын нэр
	Ажилладаг салбар
	Хөдөлмөрлөж эхлэх хугацаа
	Хөдөлмөрлөж дуусах хугацаа
	ХХҮЕГ-ын албан бичгийн дугаар
4.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дуусаж хасалт хийсэн бүртгэл	
Уригч байгууллагын регистрийн дугаар ХХҮЕГ-ын албан бичгийн дугаар	Овог
	Нэр
	Төрсөн огноо
	Хүйс
	Паспортын дугаар
	Улс
	Хөдөлмөр эрхэлж байсан хаягын бүртгэл /аймаг, нийслэл, дүүрэг/
	Уригч байгууллагын регистрийн дугаар
	Уригч байгууллагын нэр
	Ажиллаж байсан салбар
	Хөдөлмөрлөж дуусах хугацаа
	ХХҮЕГ-ын албан бичгийн дугаар

ГИХГ, ХХҮЕГ – ын хооронд байгуулсан 2019 оны
... дугаартай "Мэдээлэл солилцох гэрээ"-ний 2 дугаар хавсралт

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАРТ ӨГӨХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Оролтын утга	Гаралтын утга /Гаралтын утга нь тухайн оны 01-р сарын 01- ний өдрөөс эхэлж тухайн хайлт хийж буй өдөр хооронд байна/
1.Хөдөлмөр эрхлүүлэхээр визийн зөвшөөрөл авсан мэдээлэл	
Уригч байгууллагын регистрийн дугаар	Овог
	Нэр
	Төрсөн огноо
	Хүйс
	Паспортын дугаар
	Улс
	Уригч байгууллагын регистрийн дугаар
	Уригч байгууллагын нэр
	Визийн зөвшөөрлийн дугаар
2.Хөдөлмөх хугацааг сунгасан зөвшөөрлийн мэдээлэл	
Уригч байгууллагын регистрийн дугаар	Овог
	Нэр
	Төрсөн огноо
	Хүйс
	Паспортын дугаар
	Улс
	Оршин суугаа хаяг /аймаг, хот, сум, дүүрэг/
	Уригч байгууллагын регистрийн дугаар
	Уригч байгууллагын нэр
	Хөдөлмөрлөж эхлэх хугацаа
	Хөдөлмөрлөж дуусах хугацаа
	ХХҮЕГ-ын албан бичгийн дугаар
3.Хөдөлмөрлөх зөвшөөрлийн хугацаа дуусаж хасалт хийсэн бүртгэл	
Уригч байгууллагын регистрийн дугаар	Овог
	Нэр
	Төрсөн огноо
	Хүйс
	Паспортын дугаар